САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 04 сарын 14 өдөр Дугаар 129 Улаанбаатар хот

Хаалттай хүрээнд нэмж гаргаж буй
энгийн хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор батлсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Тандэм инвэст ББСБ" ХК-ийн хаалттай хүрээнд нэмж гаргаж буй 2 /хоёр/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 134,953,581 /нэг зуун гучин дөрвөн сая есөн зуун тавин гурван мянга таван зуун наян нэг/ ширхэг энгийн хувьцааг бүртгэн, тус компанийн нийт гаргасан хувьцааг 1,131,087,531 /нэг тэрбум нэг зуун гучин нэгэн сая наян долоон мянга таван зуун гучин нэг/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /С.Цэрэндаш/-т үүрэг болгож, нэмж гаргаж буй энгийн хувьцааг үнэт цаас гаргагчийн тодорхойлсон хувьцаа эзэмшигчийн өмчлөлд бүртгэхийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос батлсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллахыг "Тандэм инвэст ББСБ" ХК /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд үүрэг болгосугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН